

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Баянхонгор сумын Номгон сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **БНА-2022/1/НА-СТА-ТШЗ**

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576      Цахим хаяг: <a href="mailto:munkhbatb@audit.gov.mn">munkhbatb@audit.gov.mn</a> Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140      Цахим хаяг: <a href="mailto:tseenyama@audit.gov.mn">tseenyama@audit.gov.mn</a> Аудитор: Н.Бүнчинсүрэн Утас: 99049866      Цахим хаяг: <a href="mailto:bunchinsuren@audit.gov.mn">bunchinsuren@audit.gov.mn</a>  Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл .....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт.....	16
4.1 Албан шаардлага .....	16
4.2 Зөвлөмж.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	17

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,  
Баянхонгор аймаг, 64101  
Утас, факс 7044 2584  
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.25 № 2/109

БАЯНХОНГОР СУМЫН НОМГОН  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Л.САРАНГЭРЭЛ ТАНАА

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын Номгон сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын Номгон сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


D:\alban bichig\A4-toot.docx

• 005020504

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

A handwritten signature in black ink, consisting of several loops and a long horizontal stroke, is written over a faint red rectangular stamp. The stamp contains some illegible text.

Б.МӨНХБАТ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	төгрөгөөр	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>199,415,225.55</b>	<b>249,997,168.75</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	1,444,378.00	3,002,348.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	1,444,378.00	3,002,348.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	3,002,348.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,444,378.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	197,970,847.55	246,994,820.75
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	79,136,361.91	110,199,416.11
35110	Тусгай зориулалттай материал	64,600,491.91	84,390,106.11
35130	Эм боох материал	14,535,870.00	25,809,310.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	118,834,485.64	136,795,404.64
35410	Бичиг хэргийн материал	7,814,520.00	8,368,800.00
35420	Аж ахуйн материал	10,090,080.00	11,494,361.00
35450	Барилгын засварын материал	1,454,000.00	1,454,000.00
35470	Бусад хангамжийн материал	99,475,885.64	115,478,243.64
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,976,070,419.12</b>	<b>2,606,257,434.75</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,976,070,419.12	2,606,257,434.75
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,099,378,752.42	1,790,865,768.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,098,738,564.50	1,728,173,183.90
39202	Хуримтлагдсан элэгдэл	-203,069,289.67	-236,409,535.87
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	489,066,218.23	553,156,521.63
39206	Хуримтлагдсан элэгдэл	-409,238,659.03	-435,658,798.16
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	162,943,185.40	231,227,798.06
39208	Хуримтлагдсан элэгдэл	-99,556,295.01	-113,067,771.55
39214	Бусад үндсэн хөрөнгө	32,413,358.00	32,413,358.00
39217	Ном	28,081,670.00	31,031,012.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	876,691,666.70	815,391,666.74
39301	Програм хангамж	8,492,798.00	8,492,798.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-4,376,131.30	-5,676,131.26
39303	Бусад биет бус хөрөнгө	872,575,000.00	812,575,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>3,175,485,644.67</b>	<b>2,856,254,603.50</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,596,157.07</b>	<b>39,901.82</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	1,596,157.07	39,901.82
<b>413</b>	<b>Өглөг</b>	1,596,157.07	39,901.82
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,596,157.07	00.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	00.00	39,901.82
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	39,901.82
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,173,889,487.60</b>	<b>2,856,214,701.68</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,173,889,487.60	2,856,214,701.68
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,498,705,779.83	2,498,705,779.83
51101	Өмч: - төрийн	2,498,705,779.83	2,498,705,779.83
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-2,480,236,595.56	-2,797,911,381.48
51210	Өмнөх үеийн үр дүн	-2,480,236,595.56	-2,480,236,595.56
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-317,674,785.92
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,155,420,303.33	3,155,420,303.33
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,175,485,644.67</b>	<b>2,856,254,603.50</b>

**Баянхонгор сумын Номгон Ерөнхий боловсролын сургуулийн  
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

				Төгрөгөөр
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,976,749,478.35</b>	<b>3,149,957,046.26</b>	
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>91,635,184.35</b>	<b>241,696,418.26</b>	
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>91,635,184.35</b>	<b>241,696,418.26</b>	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	91,635,184.35	487,977.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,000,000.00	35,000.00	
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	00.00	452,977.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	82,635,184.35	00.00	
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого бараа материал	00.00	17,714,114.20	
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого үндсэн хөрөнгө	00.00	223,494,327.06	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,885,114,294.00</b>	<b>2,908,260,628.00</b>	
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,429,834,200.00</b>	<b>2,400,204,600.00</b>	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,429,834,200.00	2,400,204,600.00	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>132,793,694.00</b>	<b>144,271,964.00</b>	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	128,923,174.00	117,340,704.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,870,520.00	26,931,260.00	
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>322,486,400.00</b>	<b>363,784,064.00</b>	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	322,486,400.00	363,784,064.00	
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,927,277,081.92</b>	<b>2,962,487,550.58</b>	
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,927,277,081.92</b>	<b>2,962,487,550.58</b>	
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,671,198,664.47</b>	<b>2,723,065,478.58</b>	
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,921,713,431.36</b>	<b>1,917,297,692.00</b>	
210101	Үндсэн цалин	1,575,455,153.36	1,556,541,024.00	
210102	Нэмэгдэл	346,258,278.00	360,756,668.00	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>237,779,399.63</b>	<b>249,627,427.93</b>	
210201	Тэтгэврийн даатгал	163,256,670.63	174,204,932.93	
210202	Тэтгэмжийн даатгал	19,386,494.00	19,454,764.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,492,396.00	15,446,209.00	
210204	Ажилгүйдлийн даатгал	3,603,986.00	3,683,774.00	
210205	Эрүүл мэндийн даатгал	36,039,853.00	36,837,748.00	
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>317,566,603.00</b>	<b>352,309,360.00</b>	
210301	Гэрэл, цахилгаан	16,741,024.00	9,304,086.00	
210302	Түлш, халаалт	265,867,965.00	308,103,442.00	
210303	Цэвэр, бохир ус	34,957,614.00	34,901,832.00	
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>30,270,549.00</b>	<b>19,872,060.82</b>	
210401	Бичиг хэрэг	5,326,280.00	4,867,400.00	
210402	Тээвэр, шатахуун	2,200,000.00	2,000,000.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,071,429.00	3,738,908.82	
210404	Ном, хэвлэл	132,000.00	132,000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,743,580.00	1,200,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,298,250.00	6,569,932.00	
210408	Бараа материал акталсны зардал	5,499,010.00	1,363,820.00	
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>3,628,150.00</b>	<b>12,920,910.00</b>	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,508,150.00	12,920,910.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	120,000.00	00.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>11,312,873.00</b>	<b>18,750,800.00</b>	
210604	Урсгал засвар	11,312,873.00	18,750,800.00	
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>289,000.00</b>	<b>685,000.00</b>	
210702	Дотоод албан томилолт	289,000.00	685,000.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,043,000.00</b>	<b>18,984,800.00</b>	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,443,000.00	18,342,800.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	42,000.00	

Баянхонгор сумын Номгон Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>144,595,658.48</b>	<b>132,617,427.83</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	868,200.00	5,135,598.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,007,200.00	1,363,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	142,720,258.48	126,118,029.83
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>256,078,417.45</b>	<b>239,422,072.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>200,377,043.00</b>	<b>190,523,122.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	59,257,650.00	64,176,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,573,451.00	82,358,207.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	104,897,266.00	33,182,634.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,648,676.00	10,806,181.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>2,372,774.00</b>	<b>1,895,700.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,919,797.00	00.00
213404	Хөрөнгийн	452,977.00	1,895,700.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>53,328,600.45</b>	<b>47,003,250.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	53,328,600.45	47,003,250.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>49,472,396.43</b>	<b>187,469,495.68</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>505,144,281.60</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	505,144,281.60
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>00.00</b>	<b>-505,144,281.60</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>49,472,396.43</b>	<b>-317,674,785.92</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,894,114,294.00</b>	<b>2,908,748,605.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>12,870,520.00</b>	<b>487,977.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>12,870,520.00</b>	<b>487,977.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,870,520.00	487,977.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,290,000.00	35,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	580,520.00	00.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	00.00	452,977.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,881,243,774.00</b>	<b>2,908,260,628.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,429,834,200.00</b>	<b>2,400,204,600.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,429,834,200.00	2,400,204,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>128,923,174.00</b>	<b>144,271,964.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	128,923,174.00	117,340,704.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		26,931,260.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>322,486,400.00</b>	<b>363,784,064.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	322,486,400.00	363,784,064.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,820,076,724.00</b>	<b>2,870,793,805.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,820,076,724.00</b>	<b>2,870,793,805.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,564,335,750.55</b>	<b>2,631,437,914.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,919,653,782.54</b>	<b>1,910,373,243.00</b>
210101	Үндсэн цалин	1,328,950,058.45	1,369,539,079.00
210102	Нэмэгдэл	420,571,206.40	405,505,803.00
210104	Урамшуулал	170,132,517.69	135,328,361.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>240,040,113.01</b>	<b>259,231,300.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	165,983,537.30	193,686,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	19,153,189.71	16,670,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,322,595.75	12,427,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,830,682.76	3,106,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	35,750,107.49	33,340,500.00

**Баянхонгор сумын Номгон Ерөнхий боловсролын сургуулийн  
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		
210301	Гэрэл, цахилгаан	317,566,603.00	352,784,064.00
210302	Түлш, халаалт	9,500,758.00	9,778,790.00
210303	Цэвэр, бохир ус	273,108,231.00	308,103,442.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		
210401	Бичиг хэрэг	34,957,614.00	34,901,832.00
210402	Тээвэр, шатахуун	32,440,579.00	15,384,507.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,444,220.00	2,880,000.00
210404	Ном, хэвлэл	2,200,000.00	2,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,371,429.00	3,699,007.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,092,000.00	286,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>		
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,563,580.00	1,200,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,769,350.00	5,319,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,724,300.00	5,455,520.00
210602	Тавилга	10,252,600.00	1,685,000.00
210604	Урсгал засвар	5,471,700.00	3,770,520.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		
210702	Дотоод албан томилолт	16,492,873.00	27,785,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,422,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	24,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	14,046,873.00	27,785,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	289,000.00	685,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	289,000.00	685,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	255,740,973.45	239,355,691.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	200,039,599.00	190,456,741.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	59,257,650.00	64,176,100.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,573,451.00	82,358,207.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	104,897,266.00	33,182,634.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>		
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>		
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	12,311,232.00	10,739,800.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>		
		<b>2,372,774.00</b>	<b>1,895,700.00</b>
		<b>2,372,774.00</b>	<b>1,895,700.00</b>
		<b>53,328,600.45</b>	<b>47,003,250.00</b>
		<b>53,328,600.45</b>	<b>47,003,250.00</b>
		<b>74,037,570.00</b>	<b>37,955,000.00</b>
		<b>-74,037,570.00</b>	<b>-37,955,000.00</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,498,706,779.83	3,155,420,303.33	-	3,124,417,091.17
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	49,472,396.43	49,472,396.43

Баянхонгор сумын Номгон Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан					
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,498,705,779.83	3,155,420,303.33	2,480,236,595.56	3,173,889,487.60
D01	2021 оны 01-р сарын 30-нээрх үлдэгдэл	2,498,705,779.83	3,155,420,303.33	2,480,236,595.56	3,173,889,487.60
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,498,705,779.83	3,155,420,303.33	2,480,236,595.56	3,173,889,487.60
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-317,674,785.92	-317,674,785.92
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,498,705,779.83	3,155,420,303.33	2,797,911,381.48	2,856,214,701.68

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,793,168,200.00	2,717,020,414.00	76,147,786.00	97.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,793,168,200.00	2,717,020,414.00	76,147,786.00	97.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,673,177,500.00	2,642,104,514.00	31,072,986.00	98.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,915,064,700.00	1,910,373,243.00	4,691,457.00	99.8
210101	Үндсэн цалин	1,415,421,600.00	1,369,539,079.00	45,882,521.00	96.8
210102	Нэмэгдэл	379,197,000.00	405,505,803.00	-26,308,803.00	106.9
210104	Урамшуулал	120,446,100.00	135,328,361.00	-14,882,261.00	112.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	263,460,400.00	259,231,300.00	4,229,100.00	98.4
210201	Тэтгэврийн даатгал	195,694,100.00	193,686,100.00	2,008,000.00	99.0
210202	Тэтгэмжийн даатгал	16,941,600.00	16,670,100.00	271,500.00	98.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,553,300.00	12,427,700.00	1,125,600.00	91.7
210204	Ажилгүйдлийн даатгал	3,388,300.00	3,106,900.00	281,400.00	91.7
210205	Эрүүл мэндийн даатгал	33,883,100.00	33,340,500.00	542,600.00	98.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	371,963,600.00	352,784,064.00	19,179,536.00	94.8
210301	Гэрэл, цахилгаан	13,578,900.00	9,778,790.00	3,800,110.00	72.0
210302	Түлш, халаалт	322,106,700.00	308,103,442.00	14,003,258.00	95.7
210303	Цэвэр, бохир ус	36,278,000.00	34,901,832.00	1,376,168.00	96.2
2104	Хангамж, бараа материалын зардал	18,681,600.00	15,789,507.00	2,892,093.00	84.5
210401	Бичиг хэрэг	2,686,000.00	2,880,000.00	-194,000.00	107.2
210402	Тээвэр, шатахуун	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,448,600.00	3,699,007.00	749,593.00	83.1
210404	Ном, хэвлэл	3,027,500.00	691,000.00	2,336,500.00	22.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	1,200,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,319,500.00	5,319,500.00	0.00	100.0
2105	Нормативд зардал	5,465,500.00	5,455,520.00	9,980.00	99.8
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,693,400.00	1,685,000.00	8,400.00	99.5
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,772,100.00	3,770,520.00	1,580.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,785,900.00	30,785,900.00	0.00	100.0

Баянхонгор сумын нэгдсэн Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан					
210602	Тавилга	3,000,000.00	3,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	27,785,900.00	27,785,900.00	0.00	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>753,500.00</b>	<b>685,000.00</b>	<b>68,500.00</b>	<b>90.9</b>
210702	Дотоод албан томилолт	753,500.00	685,000.00	68,500.00	90.9
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>10,723,800.00</b>	<b>10,723,800.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,883,800.00	9,883,800.00	0.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	240,000.00	0.00	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>56278500.00</b>	<b>56276180.00</b>	<b>2,320.00</b>	<b>100.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,400,000.00	27,398,380.00	1,620.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	28,878,500.00	28,877,800.00	700.00	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>119990700.00</b>	<b>74915900.00</b>	<b>45,074,800.00</b>	<b>62.4</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>119,990,700.00</b>	<b>74,915,900.00</b>	<b>45,074,800.00</b>	<b>62.4</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	109,250,900.00	64,176,100.00	45,074,800.00	58.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,739,800.00	10,739,800.00	0.00	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,793,168,200.00</b>	<b>2,717,020,414.00</b>	<b>76,147,786.00</b>	<b>97.3</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,400,204,600.00</b>	<b>2,353,201,350.00</b>	<b>47,003,250.00</b>	<b>98.0</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,400,204,600.00	2,353,201,350.00	47,003,250.00	98.0
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>382,963,600.00</b>	<b>363,784,064.00</b>	<b>19,179,536.00</b>	<b>95.0</b>
132001	Орон нутгийн төсвөөс	382,963,600.00	363,784,064.00	19,179,536.00	95.0
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>10,000,000.00</b>	<b>35,000.00</b>	<b>9,965,000.00</b>	<b>0.4</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.00	35,000.00	9,965,000.00	0.4
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>141</b>	<b>148</b>	<b>-7</b>	<b>105</b>
620001	Удирдах ажилтан	1	1	0	100
620002	Гүйцэтгэх ажилтан	37	38	-1	103
620003	Үйлчлэх ажилтан	103	109	-6	106
630001	Төрийн өмчит ЕБС	2554	2554	0	100
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	102	109	-7	107
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	2	2	0	100
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	37	37	0	100

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>135,271,237.00</b>	<b>142,829,241.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>135,271,237.00</b>	<b>142,829,241.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>6,800,520.00</b>	<b>27,288,400.00</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,800,520.00</b>	<b>27,288,400.00</b>
<b>210801</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж</b>	<b>6,800,520.00</b>	<b>27,288,400.00</b>
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>128,470,717.00</b>	<b>115,540,841.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>128,470,717.00</b>	<b>115,540,841.00</b>
<b>213207</b>	<b>Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж</b>	<b>23,573,451.00</b>	<b>82,358,207.00</b>
<b>213208</b>	<b>Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг</b>	<b>104,897,266.00</b>	<b>33,182,634.00</b>
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>135,271,237.00</b>	<b>142,829,241.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>135,271,237.00</b>	<b>142,829,241.00</b>
<b>131104</b>	<b>Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө</b>	<b>128,470,717.00</b>	<b>115,540,841.00</b>
<b>131105</b>	<b>Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого</b>	<b>6,800,520.00</b>	<b>27,288,400.00</b>

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор сумын Номгон Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын Номгон Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022-ны 1 дүгээр сарын 25 өдрийн 5 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

2021 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Баянхонгор сумын Номгон сургуулийн захирал Л.Сарангэрэл 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Т.Цэрэндолгор нар зурж байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Баянхонгор сумын Номгон Ерөнхий боловсролын сургууль нь “Хүн байх ухааныг дээдэлдэг, сурах арга барилыг эзэмшсэн суралцагчидтай сургууль байна” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Санхүү хяналт, аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор сумын Номгон Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын Номгон Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,927,277.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 29,272.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 21,954.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход гүйцэтгэлийн материаллаг байдал 29,624.9 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор сумын Номгон Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 2,856,254.6 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 319,231.0 мянган төгрөгөөр буюу 10.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>199,415.2</b>	<b>249,997.2</b>	<b>50,581.9</b>
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	1,444.4	3,002.3	1,558.0
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	197,970.8	246,994.8	49,024.0
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,976,070.4</b>	<b>2,606,257.4</b>	<b>(369,813.0)</b>
Үндсэн хөрөнгө	3,692,310.8	3,397,069.7	(295,241.1)
Хуримтлагдсан элэгдэл	(716,240.4)	(790,812.2)	(74,571.9)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,175,485.6</b>	<b>2,856,254.6</b>	<b>(319,231.0)</b>
Өр төлбөр	1,596.2	39.9	(1,556.3)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,173,889.5	2,856,214.7	(317,674.8)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,175,485.6</b>	<b>2,856,254.6</b>	<b>(319,231.0)</b>

Авлагын дансны 3,002.3 мянган төгрөг болж 1,558.0 мянган төгрөгөөр өссөн нь нийгмийн даатгалын шимтгэлийн илүү шилжүүлсэн авлага 2,524.3 мянга, гэрэл цахилгааны төлбөрт 474.7 мянган төгрөг тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 197,970.8 мянган төгрөг болж 49,024.0 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал, эм боох материал, аж ахуйн материал, бусад хангамжийн материал өссөнтэй холбоотой байна.

Энэ нь БШУЯ-наас 8,777.4 мянган төгрөгийн 156 нэр төрлийн хими, физикийн хичээлийн лаборатори багаж хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүн, Дэлхийн зөн олон улсын байгууллагаас эм боох материал болон бусад хангамжийн материалын материал 4,019.7 мянга, Баянхонгор сумын Онцгой комиссоос 1,810.0 мянган төгрөгийн эм боох материал, Баянхонгор аймгийн онцгой комиссоос 1,500.0 мянган төгрөгийн тест оношлуур нийт 17,714.1 мянган төгрөгийн материал үнэ төлбөргүй шилжүүлэн ба төсвийн хөрөнгөөр бараа материал авч нөөцөлсөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,397,069.7 мянган төгрөг болж 295,241.1 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 37,955.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, 223,494.3 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хөрөнгө шилжүүлэн авсан ба Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021.12.14-ны өдрийн 139 дүгээр тогтоолоор аймгийн Боловсрол, соёлын урлагийн газарт 555,556.1 мянган төгрөгийн барилга, газрын хамт, насан туршийн боловсролын төвд 1,134.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг шилжүүлсэнтэй холбоотой байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

д/д	Нийлүүлэгчийн нэр	Барилга	Машин тоног төхөөрөмж	Тавилга эд хогшил	Ном	Нийт дүн
1	ОНХСан	124,990.8				124,990.8
2	БСШУЯ		19,905.8	64,750.4		84,656.2
3	Дэлхийн зөн		2,520.0	534.2		3,054.2
4	ХААН Кастл ХХК		8,248.8			8,248.8
5	Аз хур ХХК				917.0	917.0
6	Мон судар ХХК				366.3	366.3
7	Сонсголгүй боловсрол				1,261.1	1,261.1
	нийт дүн	124,990.8	30,674.6	65,284.6	2,544.3	223,494.3

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,856,254.6 мянган төгрөг болж 317,674.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 317,674.8 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,460,446.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 3,460,446.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 978,919.9 мянган төгрөгөөр бууруулж 2,481,526.6 мянган төгрөгөөр анх батлагдсан ба төсөвт 3 удаа өөрчлөлт оруулан тодотголоор 2,793,168.2 мянган төгрөг болгож 311,641.6 мянган төгрөгөөр буюу цалин,

НДШ, байр ашиглалттай холбоотой зардал, эд хогшил худалдан авах зардал нэмэгдүүлэн баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,793,168.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 2,717,020.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 76,147.8 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс тусгай зориулалтын шилжүүлгээр 2,400,204.6 мянга, орон нутгийн төсвөөс 363,784.1 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 35.0 мянган төгрөгийн орлого орж, урсгал үйл ажиллагаанд 2,717,020.4 мянган төгрөгийг зарцуулж тусгай зориулалтын шилжүүлгээс 47,003.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Мөн орон нутгийн төсвөөс санхүүжихээр 382,963.6 мянган төгрөг төлөвлөсөн ба төсвийн хуваарьт өөрчлөлт оруулаагүй 19,179.5 мянган төгрөгийг дутуу санхүүжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,717,020,4 мянган төгрөг буюу 97.3 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлаас 4,691.5 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 4,229.1 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 19,179.5 мянга, хангамж бараа материалын зардал 2,892.1 мянга, үдийн цайны зардлаас 45,074.8 мянган төгрөг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 144,724.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж 142,829.2 мянган төгрөг зарцуулж 1,895.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн ба дээд шатны төсөв захирагчаас 84,158.1 мянган төгрөгийг 4 багш, ажиллагсад тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, 33,182.6 мянган төгрөгийг 8 багшид хөдөө орон нутагт тогтвортой ажилласан албан хаагчдад төрөөс дэмжлэг үзүүлэх тэтгэмж, БШУЯ-наас хэрэгжүүлж буй боловсролын чанарын шинэчлэл төслийн хүрээнд “ Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим” төсөл хэрэгжиж 10,600.0 мянган төгрөг, аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газраас 15,000.0 мянган төгрөгийн “Мэргэжлийн чиг баримжаа олгох төсөл”, боловсролын хоцрогдол арилгах төсөл, БШУЯ-аас сурагчдын түвшин тогтоох шалгалтын бичиг хэргийн зардалд 1,331.3 мянга, өмнөх оны нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлсэн орлогоос 453.0 нийт 144,937.2 мянган төгрөгийн орлого орж гүйцэтгэлээр 143,041.5 мянган төгрөг зарцуулж 1,895.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитор П.Амаржаргал аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зорилго, 3 зорилтын хүрээнд 36 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 95.9 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 2,962,487.6 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 173,207.6 мянган төгрөгөөр буюу 5.8 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, байр ашиглалттай холбоотой зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж тус тус нэмэгдсэн, цалин хөлс болон нэмэгдэл урамшил, хангамж бараа материалын зардал, нормативд зардал, үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 3,407,191.0 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас иж бүрэн мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна. Харин Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт

хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт 3 дугаар улирлын мэдээлэл, Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт 9 сарын мэдээллийг дахиж орсноос

Д/Д	Хугацаа	Төрөл	Мэдээлвэл зохих/удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9	0	2
2	Хагас жил	4	4	4	0	
3	Улирал бүр	1	4	3	1	
4	Сар бүр	3	36	36	0	
5	Тухай бүр	8	96	95	1	
	Нийт	27	151	147	2	2

шалтгаалж хоцорсон төлөвтэй байна.

### **3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт**

Тайлант онд нийт 2,793,168.2 мянган төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр 2,717,020.4 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 66,182.8 мянган төгрөг буюу төсвийн 13 хувийг буцаан төвлөрүүлсэн нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

Мөн үдийн цайны зардал нь оны эхэнд 188,214.3 мянган төгрөгөөр батлагдсан ба 124,038.2 мянган төгрөгөөр бууруулж аймгийн Санхүү Төрийн сангийн хэлтэст бүлэг хооронд гүйлгэн зарцуулах хүсэлт өгч цалин, НДШ, эд хогшил худалдан авах, гамшгийн эрсдэлийн сан, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд тус тус гүйлгэн зарцуулсан байна.

Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 322,025.3 мянган төгрөгөөр, тодотголоор 19,179.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж оны эцэст 352,784.1 мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь тус сургуулийн өргөтгөлийн барилга 2021.11.08-нд ашиглалтад орсноос 38,511.2 мянган төгрөг нэмэгдэж батлагдсан ба "Төсөвт байгууллагын халаалтын зардлын төлөвлөлт гүйцэтгэл" гүйцэтгэлийн аудитын албан шаардлагын дагуу ФЮМ ХХК халаах талбайн хэмжээг 2021.09.15-аас бууруулснаас төсөвт 14,003.3 мянган төгрөгийн хэмнэлт гарсан байна.

### **3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 17471.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгсөн ба хэрэгжилтийг Номгон сургуулийн захирлын 2021.06.15-ны өдрийн 75 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Байхгүй.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар 57,522.9 мянган төгрөгийн зөрчил илэрч 1,531.9 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 777.3 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 55213.3 мянган төгрөгийн алдаа зөрчил давтан гаргахгүй байх 1 зөвлөмж хүргүүлээ.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **4.1 Албан шаардлага**

1.Багш Д.Отгонбилэг нь 2021.05.01-ээс жирэмсэн, амаржсаны чөлөө авсан ба 6 сард 2,194.7 мянган төгрөгийн амралтын цалин олгосон бөгөөд жирэмсэн амаржсаны чөлөө дуусаж ээлжийн амралтын хоногийг гүйцээж 2021.11.01-нд ажилдаа буцаж орсон байна. Харин 2021 оны 10,11 сард амралтын цалинг мэдээлэх байтал 420.0 мянган төгрөгөөр 06 кодоор мэдээлж 1,531.9 мянган төгрөгийн амралтын цалинг мэдээлээгүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 зүйлийн 17.1 дэх хэсэгт "1.Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл

**Баянхонгор сумын Номгон Ерөнхий боловсролын сургуулийн  
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ” 17.1.1 дэх “Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн:** Багш Д.Отгонбилэгийн 1,531.9 мянган төгрөгийн амралтын цалинг хуульд заасан хувь хэмжээгээр нөхөн мэдээлэх албан шаардлага хүргүүлэв.

**4.2 Төлбөрийн акт**

1. Тосуйн гол ХХК нь тухайн сургуулийн “Үдийн хоол” хөтөлбөрийг хэрэгжүүлж 38.5 м3 талбайг түрээсэлж тайлант оны 9 дүгээр сард 17 хоног, 10 сарын 14-өөс 12 сарын 10-ыг дуустал 53 хоног танхимаар хичээллэсэн хугацаанд түрээсийн төлбөр болох 777,300 төгрөгийг төлөөгүй, гэрээний үүргээ биелүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “ Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн:** Түрээсийн төлбөр болох 777,300 төгрөгийг Тосуйн гол ХХК-аар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

**4.3 Зөвлөмж**

2. Тайлант онд нийт 2,793,168.2 мянган төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр 2,717,020.4 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 66,182.8 мянган төгрөг буюу төсвийн 13 хувийг буцаан төвлөрүүлсэн нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

Мөн үдийн цайны зардал нь оны эхэнд 188,214.3 мянган төгрөгөөр батлагдсан ба 124,038.2 мянган төгрөгөөр бууруулж аймгийн Санхүү Төрийн сангийн хэлтэст бүлэг хооронд гүйлгэн зарцуулах хүсэлт өгч цалин, НДШ, эд хогшил худалдан авах, гамшгийн эрсдэлийн сан, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд тус тус гүйлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “ Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1 “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж**

Цаашид Засгийн газраас төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар гаргасан тогтоол болон журмыг хэрэгжүүлэн ажиллах

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/											
д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянхонгор сумын Номгон ЕБС	3	57,522.5			1	777.3	1	1,531.9	1	55,213.3

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_